**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 12 өдөр Дугаар А/21 Номгон

Согтууруулах ундаа худалдах,
үйлчлэх тусгай зөвшөөрөл
шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль 15 дугаар зүйлийн 15.3, $15^1$.4, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох аж ахуйн нэгжийн мэдээллийг хавсралтаар баталсугай.

2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлж ажиллахыг аж ахуйн нэгжийн захирал нарт, холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хошууч (Т.Цэвээндорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

63010049

D:\2026\1.Zakhiramj\Zakhiramj 1.docx

Аймгийн Засаг даргын 2026 оны 01
дүгээр сарын 12 -ны өдрийн 01/21 дүгээр
захирамжийн хавсралт

# СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ “ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ШИНЭЭР ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Аж ахуйн нэгжийн өмчлөгчийн нэр | Аж ахуйн нэгжийн нэр | Цэг салбарын нэр, төрөл | Цэг салбарын хаяг | Шинээр олгох, сунгах эсэх | Дуусах огноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Э.Намжил | Цогт шарман ХХК | Баян шарман Хүнсний дэлгүүр | Эрдэнэцогт сум 6-р баг | шинээр | 2031.01.12 |
| 2. | П.Ганбилэг | Хатан шижир ХХК | Хатан шижир Хүнсний дэлгүүр | Бөмбөгөр | шинээр | 2031.01.12 |
| 3. | П.Ганбилэг | Хатан шижир ХХК | Хатан шижир ресторан | Бөмбөгөр | шинээр | 2031.01.12 |

__________оОо__________

642501737